



БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Иргэний эрх зүйн маргаан¹)

ХИЙМЭЛ ОЮУНААР ҮҮСГЭСЭН ХУУРАМЧ МЭДЭЭЛЛИЙГ ЭШ ТАТСАН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ХҮЧИН ТӨГӨЛДӨР ГЭЖ ҮЗЭХГҮЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2026 INSC 668 №11950

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 07 сарын 02-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Компанийн эрх зүйн хүрээнд үүсэх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэдэг Үндэсний компанийн эрх зүйн шүүх байгууллага (англ. National Company Law Tribunal (NCLT)) нь нэгэн хэргийг хянан шийдвэрлэж шийдвэр гаргажээ. Тухайн шийдвэрт хэргийн оролцогчоос давж заалдах журмаар гомдол гарган Үндэсний компанийн эрх зүйн давж заалдах шатны шүүх байгууллага (англ. National Company Law Appellate Tribunal in Company Appeal (NCLAT))-д хандсан байна.

NCLT-н шийдвэрийн тогтоох хэсгийн 12 дугаарт БНЭУ-ын Дээд шүүхийн өмнөх хэд хэдэн шийдвэрүүдийг шүүхийн жишиг шийдвэр байдлаар эш татсан ба тухайн шийдвэрүүддээ үндэслэн холбогдох дүгнэлтийг хийжээ. Гэвч тэдгээр шийдвэрүүд нь бодит байдал дээр байхгүй, зохиомол буюу хиймэл оюун (англ. artificial intelligence)-ыг ашиглан бичсэн байх магадлалтай талаар давж заалдах гомдол гаргагч талын өмгөөлөгчөөс маргасан байна. Ийнхүү тухайн эшилсэн шийдвэрүүдийг шалгаж үзээд хуурамч болохыг Дээд шүүхээс тогтоосон байна.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Дээд шүүхээс дээрх үүссэн нөхцөл байдлыг хянан үзээд дараах дүгнэлтийг хийсэн байна:

1. Хэрэг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага жишиг болгон эшилж буй шийдвэрийн талаар судалгаа хийсэн байх шаардлагатай. Давж заалдах шатны шүүхийн хувьд анхан шатны шүүхийн анзаараагүй, орхигдуулсан алдааг залруулах үүрэгтэй ба хэргийн оролцогч тал болон тэдгээрийг

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:
https://ibbi.gov.in/uploads/order/8e1ccab8f7b445f81034223c1d0fe7b9.pdf?utm_source=ibbi&utm_medium=order
Шүүхийн шийдвэрийг хураангуйлахдаа эх хувилбарын бүтцийг өөрчилсөн болно.



- төлөөлөн оролцож буй хуульч, өмгөөлөгчийн үндэслэж буй шүүхийн жишиг шийдвэрүүдийг нягтлан шалгах нь зүйтэй юм. Хуурамч шийдвэрийг ашиглан гарсан шийдвэр нь хууль дээдлэх ёс (англ. rule of law)-нд харшилсан, хүчин төгөлдөр бус байна.
2. Үүнээс гадна анхаарах зайлшгүй шаардлагатай зүйл бол бид хиймэл оюун бүхий технологийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх байдлаар ашиглахдаа ажиллагаа бүрд хүний хяналт зайлшгүй байх шаардлагатайг анхаарах хэрэгтэй. Хиймэл оюуныг ашигласнаар ажлын бүтээмж болоод үр дүнг дээшлүүлэх боломжтой хэдий ч зохицуулалтгүй орхигдуулах тохиолдолд ёс зүйн зөрчил, цаашлаад хэт хамааралтай байдал үүсэх зэрэг эрсдэлүүд байгааг анхаарах нь зүйтэй. Мөн хиймэл оюуныг зөвхөн туслах хэрэгсэл байдлаар ашиглахаас гадна бодож сэтгэх, шийдвэр гаргахад хүртэл ашиглах боломжтой болсон энэ цаг үед илүү анхааралтай хандах шаардлагатай байна. Иймд хиймэл оюуны хэрэглээнд бүрэн хяналт тавих нь зайлшгүй бөгөөд хэзээ, хэрхэн, ямар шатанд хэрэглэх асуудал дээр түлхүү анхаарах ёстой.
 3. Түүнчлэн шүүхүүдийн хувьд хиймэл оюуныг ашигласан бүхий л мэдээлэл, баримт зэргийг үнэн зөв эсэхийг баталгаажуулалгүйгээр ашиглахыг хориглох шаардлагатай. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй талууд, тэдгээрийн хуульч, өмгөөлөгч хиймэл оюунаар бүтээгдсэн хуурамч жишиг шийдвэрийг эш татах нь буруу бөгөөд шүүгч тухайн хуурамч баримтад үндэслэх нь ноцтой алдаанд тооцогдоно. Ийнхүү гарсан шийдвэрийг тухайн хуурамч мэдээлэл нь шийдвэрт нөлөөлсөн эсэхээс үл хамааран цуцлах нь зүйтэй. Дээд шүүхийн энэхүү шийдвэр нь хиймэл оюуны хэрэглээ бус, зөвхөн хуурамч материалыг шүүхийн жишиг шийдвэр мэт ашигласан тохиолдолд холбогдох шийдвэр болохыг, мөн тухайн хэргийн баримт, үндэслэл зэрэгтэй холбоотой ямар нэгэн дүгнэлт хийгээгүйг тодотгож байна.
 4. Дээрх үндэслэлээр холбогдох шийдвэрүүдийг цуцлан, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр анхан шатны шүүх рүү буцаан шийдвэрлэсэн байна.